

**"ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ"  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН АНХНЫ  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 04 дүгээр  
сарын 17-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа**

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 7 гишүүнээс 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн төслийн 1 дүгээр зүйлийн "автомашины нүүрсэн яндан, нүүрсэн яндангийн хаягдал" гэснийг "автомашины нүүрсэн яндан, катализатор, тэдгээрийн эд анги, хаягдал, өөдөс" гэж өөрчлөх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

"Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

"Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Г.ТЭМҮҮЛЭН**